

**АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр

Орхон аймаг

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хугацаа	Биелэлт
1	ISO стандартын гарын авлагыг сайжруулах	1.1. Чанарын гарын авлага сайжруулах саналыг авах.	Гишүүдээс гаргасан саналыг нэгтгэсэн байх:	4 сард	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO стандартын гарын авлагыг сайжруулах саналыг 5 дугаар сард стандарт хөгжүүлэлтийн багийн гишүүдээс авч саналыг чанарын гарын авлагад нэгтгэн ажиллав.
		1.2. 2024 оны комиссын төлөвлөгөөнд тусгах санал гаргах	Хуралд оролцож санал гаргасан байх	1 сард	2024 оны 01 дүгээр сарын 15-нд Стандарт хөгжүүлэлтийн багийн 2024 хийх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан ажилласан.
		1.3. Чанарын гарын авлага болон, Авлигын эсрэг хуулийн хүрээнд албан хаагч нарт АХА тэмцээн зохион байгуулах	Оролцогчид хууль болон гарын авлагаа бүрэн судалсан байх	1 сард	Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Монгол улсад анх удаа Авлигын эсрэг стандарт хэрэгжүүлсэн төрийн байгууллага бөгөөд тус хэлтсийн дэргэдэх Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх комиссын зүгээс Авлигын чанарын гарын авлага, 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлтийн талаарх мэдлэгийг бататгах зорилгоор хэлтсийн алба хаагчдын дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг зохион байгуулж ажилласан. Уг тэмцээнд хэлтсийн Үйлчилгээний хэсгийн байцаагч Э.Алтантуяа оюун ухааны хурд, хүчээ

					уралдуулан 1-р байранд орж 1 өдрийн цалинтай чөлөөгөөр шагнуулав. Жич: хавсралт 1
		1.4. Гарын авлагад саналуудыг тусган, сайжруулалт хийж, батлуулах.	Гарын авлага шинэчлэгдсэн байх:	6 сард	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO стандартын чанарын гарын авлага тус тусдаа байсныг 2024 оны 02 сард Нийгмийн даатгалын газрын үйл ажиллагаанд магадлах аудит хийсэн Монсертф ХХК аудиторчуудын зөвлөснөөр 2 чанарын гарын авлагаа нэгтгэн нэг чанарын гарын болгон шинэчилж ажилласан.
		1.5. Гарын авлага шинэчлэгдсэнтэй холбоотой холбогдох журмуудад өөрчлөлт оруулан батлуулах. - Хурлын дэг хөтлөх журам - Баримт бичиг боловсруулах журам	Гишүүд холбогдох журам зааварт өөрчлөлт оруулан батлуулсан байх:	6 сард	Чанарын гарын авлага нэгтгэсэнтэй холбоотойгоор холбогдох 3 журмыг шинэчилэн гаргаж газрын баримт бичигт бүртгүүлэн, батлуулж ажилласан.
2	ISO стандартын гарын авлагын заалт тус бүрийн хэрэгжилтийг хянаж, зөвлөмж гаргах	2.1. Гарын авлагын заалт тус бүрээр хэрэгжилтийг шалгаж, зөвлөмж боловсруулан холбогдох тасаг, нэгжид өгч, хяналт тавих	<ul style="list-style-type: none"> • Удирдамж боловсруулсан байна: • Хууль тогтоомж, холбогдох гарын авлага, журамд нийцүүлсэн байх: • Зөвлөмж өгсөн байх: 	Жилийн турш	Чанарын гарын авлага хэрэгжүүлж ажиллах бэлтгэл ажил хангагдаж, 7 сараас эхлэн төлөвлөгөөний дагуу тасаг нэгжид танилцуулан нэгэн зэрэг мөрдөж ажиллана.
		2.2. Комиссын гишүүдийн идэвх, санаачлага, оролцоог дүгнэж тайлагнах	<ul style="list-style-type: none"> • Гишүүн тус бүр тайлан бичиж комиссын даргаар дүгнүүлэх 	Жилийн турш	Төлөвлөгөөний дагуу жилийн эцэст бүх гишүүдийг оролцоог дүгнэж ажиллана.

3	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	3.1. Стандарт хөгжүүлэлтийн багийн бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлагыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжит хэлбэрээр нийгмийн даатгалын салбарын албан хаагчид болон олон нийтэд сурталчлах.	<ul style="list-style-type: none"> • Баримтжуулсан байх: • Үр дүн тооцож тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо): 	Жилийн турш	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албан ёсны пэйж хуудас болон вэб хуудсанд хавсралт 1-ийн постеруудыг байрлуулан нийт 13955 иргэнд хүрч, 342 хандалт хүлээн авсан байна. Мөн хавсралт 2 заасан зурагт хуудас хэвлэж Үйлчилгээний хэсгийн хариу олгох хэсгээс ААН-н ня-бо нарт, иргэдэд хүргэн ажилласан. Үйлчилгээний хэсгийн танхимд дэлгэц байрлуулан АТГ-с бэлтгэсэн шторкуудыг иргэдэд хүргэн ажиллаж байна Жич: хавсралт 2
		3.2. Салбарын онцлогт тохируулан стандартын нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> • 2-оос доошгүй нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах: • Үр дүнг тооцож, баримт хавсаргасан байх: • Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төв болон Жаргалант баг дээр даатгуулагчийн өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор 2090 иргэнд нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Жич: хавсралт 3
		3.3. Магадлах аудитаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.	<ul style="list-style-type: none"> • Зөвлөмжийн биелэлтийн тайланг цаасаар гаргах: 	8 сард	Төлөвлөгөөний дагуу 8 сард тайлан бичиж дуусгах.

			<ul style="list-style-type: none"> Тайланд баримтыг хавсаргасан байх: 		
		<p>3.4. Авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий цахим гарын авлага бэлтгэж, салбарын албан хаагчид болон олон нийтэд хүргэсэн байх.</p>	<ul style="list-style-type: none"> 2-аас доошгүй сурталчилгааны материал боловсруулна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр салбарын албан хаагчид болон нийтэд хүргэсэн байх (авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх): Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	<p>Авлигын стандарт нэвтрүүлж ажилласнаас хойш нийт 23 сурталчилгааны постер бүтээж, авлигаас урьдчилан сэргийлэх утгатай хөлтэй самбарт хийж, байцаагч ажилчдын ширээн дээр байрлуулах, хэлтсийн албан ёсны вэб хуудас болон пэйж хаягт байрлуулан ажилласан.</p> <p>Мөн авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулахаас гадна хэлтсийн 75776699 дугаарт залгаж, 3 хэсгээр холбогдох боломжтой болгож, сурталчлан таниулах постерууд бэлтгэсэн.</p> <p>Мөн нийгмийн даатгалаас үйлчилгээ авч буй иргэдийн бөглөх өргөдлийн загвар болон маягтад авлига мэдээлэх 110 утасны дугаар холбогдох мэдээллийг байрлуулан ажилласан</p> <p>Жич: хавсралт 4</p>
		<p>4.1. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид болон нийт албан хаагчдыг сургалтад хамруулсан байх.</p>	<ul style="list-style-type: none"> Шинэ томилогдсон болон нийт албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт, ёс зүйн сургалтад бүрэн хамруулж гэрчилгээ олгох: 	Жилийн турш	<p>Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Монгол улсад анх удаа Авлигын эсрэг стандарт хэрэгжүүлсэн төрийн байгууллага бөгөөд тус хэлтсийн дэргэдэх Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх комиссын зүгээс Авлигын чанарын гарын авлага, 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж буй</p>

4	ISO стандарт болон Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах		<ul style="list-style-type: none"> Тайланд баримтыг хавсаргасан байх: 		<p>Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлтийн талаарх мэдлэгийг бататгах зорилгоор хэлтсийн алба хаагчдын дунд танин мэдэхүйн “АХА” тэмцээнийг зохион байгуулж ажилласан. Хэлтсийн нийт байцаагч албан хаагч нарт 03 сарын 20-нд Стандарт хөгжүүлэлтийн багийн гишүүн Н.Хулан авлига, ашиг сонирхолын хор уршигийн талаар болон хэрхэн урдчилан сэргийлэх, зайлс хийх талаар сургалт орсон.</p> <p>Жич: хавсралт 5</p>
		4.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах салбар комиссын гишүүдэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдэд сургалт орсон байх: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	<p>Стандарт хөгжүүлэлтийн багийн гишүүн Н.Хулан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын нийт 7 гишүүнд 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр авлига, ашиг сонирхолын хор уршигийн талаар болон хэрхэн урдчилан сэргийлэх, зайлс хийх талаар сургалт орсон.</p> <p>Жич: хавсралт 6</p>
		4.3. Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн гишүүдэд авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах арга	<ul style="list-style-type: none"> Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүдэд сургалт орсон байна: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	<p>Стандарт хөгжүүлэлтийн багийн гишүүн Н.Хулан маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн нийт 9 гишүүнд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр авлига, ашиг сонирхолын хор уршигийн талаар болон хэрхэн урдчилан сэргийлэх, зайлс хийх талаар сургалт орсон.</p> <p>Жич: хавсралт 7</p>

		хэмжээг зохион байгуулах.			
		7.8. Дотоодын Нөөц бололцоог ашиглан албан хаагчиддаа сургалт зохион байгуулсан байх:	<ul style="list-style-type: none"> Албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад хамруулсан байх: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	Хэлтсийн нийт байцаагч албан хаагч нарт 03 сарын 20-нд Стандарт хөгжүүлэлтийн багийн гишүүн Н.Хулан авлига, ашиг сонирхолын хор уршигийн талаар болон хэрхэн урдчилан сэргийлэх, зайлс хийх талаар сургалт орсон.
5	Стандартын үйл ажиллагаанд олон нийт болон дотоод хяналтыг бий болгох	5.1. Нийгмийн даатгалын хэлтэс болон хувийн хэвшлийн байгууллагын хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж ажиллах.	<ul style="list-style-type: none"> Байгууллагын бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байна: Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулсан байх: Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж дүгнэсэн байна. Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	Хэлтсийн өр авлагын байцаагчаас ажил олгогч нартай байгуулдаг өр авлагын гэрээнд 7,8 дугаар заалт болгон нэмэлтээр Авлигын эсрэг хуулийн заалтуудыг оруулж ажилласан байна. Мөн Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст ажиллаж буй гэрээт ажилтан, төлөөлөгч нарын Хөдөлмөрийн гэрээнд Авлигын эсрэг хуулийн зохих хамаарах заалтуудыг нэмж оруулан, танилцуулж ажилласан.
		5.2. Даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хянан хэлэлцэж, биелэлтэд үнэлгээ өгөх.	<ul style="list-style-type: none"> Сургалт, мэдээлэл олгосон байна: Хурлын дэгийн журмын хэрэгжилтэд хяналт хийсэн байна байна: 	Жилийн турш	Даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хянан хэлэлцэж, биелэлтэд үнэлгээ өгөх зорилгоор хурлын дэг хөтлөх журмыг шинэчлэн батлуулж мөрдөж ажиллаж байна.

			<ul style="list-style-type: none"> Тайланд баримтыг хавсаргасан байх: 		
		<p>5.3. Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.</p>	<ul style="list-style-type: none"> Байгууллагын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсан байна: Байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр нь байршуулж ажиллана: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	<p>Орхон аймгийн хэлтсийн байрны нэг давхарт Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс самбар бүтээн, мэдээллүүдийг байрлуулсан мөн хэлтсийн байрны давхар бүрийн камерийн харагдацгүй хэсэгт авлигын өргөдөл, гомдол хүлээн авах хайрцаг болон өргөдөл гаргах зааврийг байрлуулсан байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журын дагуу газрын үйл ажиллагаанд Хяналт шалгалт дотоод аудитын хэлтэстэй хамран шалгалт хийж дутуу оруулсан мэдээллийг шалгаж нэмж оруулсан.</p>
6	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллах</p>	<p>6.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг тодорхойлох.</p>	<ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаандаа эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцож ажиллана: 	Жилийн турш	<p>Төлөвлөгөөний дагуу 9 сард хийгдэх ажил.</p>

			<ul style="list-style-type: none"> Тайланд баримтыг хавсаргасан байх: 		
		<p>6.3. Авлигаас урьдчилан сэргийлэх, хүнд суртлыг бууруулах чиглэлээр шинээр хэрэгжүүлсэн шинэлэг 2 ажлыг салбарын хэмжээнд сурталчлах.</p>	<ul style="list-style-type: none"> Байгууллагын албан ёсны цахим хуудас, нийгмийн сүлжээнд тухай бүр байршуулсан байна: Байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр нь байршуулж ажиллана: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	Төлөвлөгөөний дагуу 8 сард хийгдэх ажил.
7	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачлага өрнүүлэх	<p>7.1. 2024 оны стандартын ажиллагааны төлөвлөгөө батлан, хэрэгжилтийн явцыг эхний хагас жил, бүтэн жилээр дүгнэн ажиллах.</p>	<ul style="list-style-type: none"> Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх: Албан хаагчдаас гаргасан санал санаачлага хэлэлцсэн байх: Тайланд баримтыг хавсаргасан байх: 	Жилийн турш	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг батлуулан, батлагдсан төлөвлөгөөний дагуу хувиарласан ажлуудыг цаг хугацаанд нь гүйцэтгэж ажиллаж байна.
		<p>7.2. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалтыг оруулж, хэрэгжилтэд хяналт тавих.</p>	<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан байх: 	Жилийн турш	Байцаагч ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвгөөнд авлигын талаар заалт оруулан баталж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

8	Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах	8.1. Албан ёсны цахим хуудастай /сайт/ байх, сайтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинэчлэх, сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах.	<ul style="list-style-type: none"> • Цахим хуудасны дизайн загварыг иргэд мэдээллийг шуурхай, ойлгомжтой байдлаар олж авах боломжтой байдлаар өөрчлөн шинэчилсэн байх: • Ил тод байдалд хяналт тавих, цахим хуудастай болгох ажлыг зохион байгуулж ажилласан байх: 	Жилийн турш	Нийгмийн даатгалын ерөнхий газрын баталсан албан ёсны цахим хуудсын ажиллагааг тогтмол идэвхжүүлэн, шинэчилж, сайжруулах ажиллаж байна.
		8.2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах.	<ul style="list-style-type: none"> • Цахим хуудаст хуульд заасан нээлттэй мэдээллийг байршуулах чиг үүргийг холбогдох ажилтнуудад хариуцуулж, шийдвэр гаргаж баталгаажуулсан байх: • Хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулсан, мэдээллийг шинэчилсэн байх: 	Жилийн турш	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж нээлттэй байж болох бүх мэдээллийг цахим хуудаст хийж ажилласан.

ТАЙЛАН БИЧСЭН:

О.ЧОЙЕНМАА

Хавсралт 1

10:35

Орхон аймгийн Нийгмийн даа...

Posts About Photos More

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар
26 Jan

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь Монгол улсад анх удаа Авлигын эсрэг стандарт хэрэгжүүлсэн төрийн байгууллага бөгөөд тус хэлтсийн дэргэдэх Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх зөвлөлийн зүгээс Авлигын эсрэг стандартын чанарын гарын авлага, 2024.01.01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлтийн талаарх мэдлэгийг бататгах зорилгоор хэлтсийн алба хаагчдын дунд танин мэдэхүйн "АХА" тэмцээнийг зохион байгуулж ажиллалаа.

Уг тэмцээнд Үйлчилгээний хэсгийн байцаагч Э.Алтантуяа оюун ухааны хурд, хүчээ уралдуулан 1-р байранд шалгарлаа. 🏆🏆🏆



Хавсралт 2



Хавсралт 3



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

17 May · 🌐

✅ "Орхон аймгийн Жаргалант сумын ЗДТГазар"-аас "Төрийн үйлчилгээг иргэн бүрд тэгш хүртээмжтэй, түргэн шуурхай, чанартай хүргэх зорилгы... See more



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

27 May · 🌐

✅ Нийгмийн даатгалын хамрагдалт нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд 2024 оны 05-р сарын 24-ны өдөр "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгууллаа. Өдөрлөгөөр нийт 86 иргэд, даатгуулагчдад зөвлөгөө, мэдээлэл өгч иргэдийн саналт хүсэлтийг авч ажиллалаа.

✅ Хамтран ажилласан байгууллагуудад аа талархал илэрхийлье.



Хавсралт-4



ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ГАРГАХ БОЛОМЖТОЙ ХЭЛБЭР

- Иргэн, хуулийн этгээдээс гаргаж буй өргөдөл, гомдол, мэдээллийг зөвхөн 110 тусгай дугаарын утсаар хүлээж авна.
- contact@iaac.mn
- Авилгатай тэмцэх газрын Олон нийтийн төв, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах ажилтантай биечлэн ирж уулзаж өгөх.
- www.iaac.mn цахим хуудсанд нэвтэрч Гомдол, мэдээллийн маягтын дагуу илгээнэ.
- Авилгатай тэмцэх газар, 5-р хороолол, Сөүлийн гудамж 41, Улаанбаатар хот-14250, Монгол улс

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧЛИЙГ МЭДЭЭЛЭХ УТАС: 110

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар
59m · 🌐

Та авлига, ёс зүйтэй холбоотой санал, гомдол өгөх бол 75776699-3 холбоосоор холбогдоорой.

НИЙГМИЙН ДААТГАЛ АВЛИГАГҮЙ БҮС

Та авлига, ёс зүйтэй холбоотой санал, гомдол өгөх бол 75776699 /3/

Хавсралт-5



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

5 Apr · 🌐

✅ Байгууллагын албан хаагч, ажилчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, шинэ систем дээр тулгамдаж байгаа асуудал тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, ажилчдыг идэвхжүүлэх зорилгоор дотооддоо сургалт зохион байгууллаа.



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар

15 May · 🌐

✅ "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооноос албан хаагч, ажилчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт дотоодын сургалт зохион байгууллаа.



Хавсралт-6



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар



3 Apr · 🌐

✅ Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд Нийгмийн даатгалын улсын байцаагч, сэтгэл зүйч Н.Хулан "Авлигын эсрэг хууль"-ийн талаарх сургалт, мэдээлэл хүргэн ажиллалаа.



Хавсралт-7

